



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/491

Булган сум

Ахмад настанд үзүүлэх цогц тусламж,
үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах
хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Журам батлах тухай” А/28, А/27 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан болон нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтны ахмад настанд үзүүлэх үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга
Аймгийн Ахмадын хорооны дарга

2. Ахмад настны тухай хуулийн дагуу үзүүлж буй тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж, холбогдох байгууллагуудыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг хамтарсан багийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010665